

**ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК-Д АШИГЛАГДАЖ БУЙ ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ
БОДИСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Эрдэнэт үйлдвэр ХХК-д ашиглах “Химийн бодисын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”

Төслийн дугаар: ЭҮХХК/201803058

Орхон аймаг 2018 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Эрдэнэт үйлдвэр ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Эрдэнэт үйлдвэр ХХК-д ашиглах “Химийн бодисын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” хийх ажлын үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг *2018 оны 06-р сарын 25-ны 10 цагаас өмнө Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн ерөнхий захиргааны 2-р байрны 110 тоотод* ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2018 оны 06-р сарын 25-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Сонирхсон этгээд ажлын даалгавартай холбоотой мэдээллийг дор дурдсан хаягаар авч болно.

Орхон аймаг Баян-Өндөр сум Уурхайчин баг Найрамдал талбай Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны 2-р байр 110 тоот

Утас: 95349263

Цахим шуудан: bayasgalan@erdenetmc.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 1.2. Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:
 - *Байгаль орчны нарийвчилсан байдлын үнэлгээ хийх эрх бүхий байгууллага*
2. Тендерийн иж бүрдэл
 - 2.1. Тендерт оролцогчдоод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үйл ажиллагааны хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
3. Тендерийн үнэ
 - 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.
 - 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
4. Дотоодын давуу эрх
 - 4.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт давуу эрхийн зөрүү тооцохгүй.
5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Алдааг залруулах
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 /хоёр/ жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; 2. Сүүлийн 2 /хоёр/ жилийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гүйцэтгэлийн акт/; 3. Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамжаа төлсөн тухай эрх бүхий байгууллагын тодорхойлолт. 4. Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээний хуулбаруудыг эх хувиас нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ;
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: <i>Орхон аймаг Баян-Өндөр сум Найрамдал талбай 1, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны 2-р байрны 1 дүгээр давхар 103 тоотод 2018 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн 10 цаг 00 минут.</i></p> <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: <i>Орхон аймаг Баян-Өндөр сум Найрамдал талбай 1, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны 2-р байрны 1 дүгээр давхар 103 тоотод 2018 оны 06 дүгээр сарын 25-ны өдөр. 10 цаг 30 минут.</i></p>
ТӨӨЗ 3.4	<p>Татвар: Тендерт оролцогч нь ажлыг гүйцэтгэхтэй холбогдон төлөгдөх бүх татвар, хураамжийг төлөх асуудлыг өөрсдөө хариуцна. Захиалагчийн зүгээс аливаа татвар, хураамжийг төлөх асуудлыг хариуцахгүй. Зөвлөхийн ирүүлэх үнийн саналд татвар, төлбөр, хураамж багтсан байна</p>

Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- | | |
|--|---|
| 1. Гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан үйлчилгээг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр үйлчилгээ дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан үйл ажиллагааны хуваарь болон төслийн менежерийн баталсан тодотгосон үйл ажиллагааны хуваарийн дагуу хийж гүйцэтгэн, үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.
4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй. |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|------------------------------|---|
| 7. Үйлажиллагаа ны хуваарь | 7.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хуваарийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Үйл ажиллагааны хуваарийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь үйл ажиллагааны хуваарийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн үзүүлсэн үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн |

аливаа үйчилгээнд зөрчил, гологдол хайх, далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- | | |
|--------------------------------------|--|
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
| | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|---------------------------------------|--|
| 11. Үйл ажиллагааны хуваарь | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарийн тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үйл ажиллагааны хуваарь нь үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна. |
| | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үйл ажиллагааны хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| 12. Үйл ажиллагааны хуваарийг өөрчлөх | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр үйлчилгээний арга барил, эсхүл үйл ажиллагааны хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үйл ажиллагааны хуваарь дахь үнийг өөрчлөхгүй. |
| 13. Алданги | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- | | |
|-----------------------|---|
| 14. Үйлчилгээ дуусгах | 14.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер үйчилгээ дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. |
|-----------------------|---|

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0,05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

15. Хүлээж авах 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
17. Гэрээг цуцлах 17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:
- (а) Үйл ажиллагааны хөтөлбөрт үйлчилгээ зогсоох тухай заагаагүй, түүнчлэн үйлчилгээ зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч үйлчилгээг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер үйлчилгээний явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
 - (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (е) гүйцэтгэгч үйлчилгээний гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 17.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч үйлчилгээг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
18. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр 18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн үйлчилгээний болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй

үйлчилгээний гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн үйлчилгээ болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, үйлчилгээний зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

19. Гүйцэтгэлээс чөлөөлөх

19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн үйлчилгээ болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Тав. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

	Гэрээний нэр: Эрдэнэт үйлдвэр ХХК-д ашиглах “Химийн бодисын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” Гэрээний бүртгэлийн дугаар: ЭҮХХК/201803058
1.1	Ажлын үндсэн зорилго нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д ашиглагдаж буй химийн хорт болон аюултай бодисууд нь ажилчдын эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөлөөллийг үнэлэх, өртөлт болон хор аюул, эрсдлийн шинж зэргийг тодорхойлж, цаашид эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөх талаар мэргэжлийн байгууллагын зөвлөмж авах
2.1	Төслийн менежер: <i>Ж.Жавхланбат “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах хэлтсийн Байгаль орчны тэргүүлэх инженер, утас: 7577-1558 /ажлын/, 99351339</i>
4.1	Ажил эхлэх, дуусах хугацааг гэрээнд зааж өгөх бөгөөд ажил гүйцэтгэх хугацаа 1,5 сар байна.
7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
	Техникийн даалгаварын дагуу ажлыг гүйцэтгэнэ. Техникийн даалгавар, ажлын төлөвлөгөө, гэрээний салшгүй нэг хэсэг байна.
9.1	Чанарын баталгаат хугацаа /тоо/ сар байна.
13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0,1 хувь байна.
	Алдангийн нийт дүн нийт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 8 хувиас хэтрэхгүй байна.
17.1	“Химийн бодисын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” ажлын тайланг 2018 оны 08 сарын 20 дотор гаргаж өгнө.

Зургаа. АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын нэр: “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д ашиглагдаж буй химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх ажил

Ажлын байршил: Орхон аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ХХК

Гэрээний төрөл: Ажил гүйцэтгэх (Аж ахуйн нэгж)

Захиалагч байгууллага: ”Эрдэнэт үйлдвэр” ХХК

Гэрээний үргэлжлэх хугацаа: 1,5

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эрдэнэт үйлдвэр ХХК нь хүдэр баяжуулалт болон бусад технологийн процессын үе шатуудад химийн хорт болон аюултай бодис материалуудыг ашиглаж байна. Импортын химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааны улмаас байгаль орчин, хүн амын (ажилчид) эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийгддэг. Эрдэнэт үйлдвэр ХХК-д ашиглагдаж буй нийт 70 төрлийн химийн хорт болон аюултай бодис, химийн бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийгдэх шаардлагатай байна.

2. ЗОРИЛГО, ҮР ДҮН

Эрдэнэт үйлдвэр ХХК-д ашиглагдаж буй химийн хорт болон аюултай бодисууд нь ажилчдын эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөлөөллийг үнэлэх, өртөлт болон хор аюул, эрсдэлийн шинж зэргийг тодорхойлж, цаашид эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөх талаар мэргэжлийн байгууллагын зөвлөмж авах.

3. ХАМРАХ ХҮРЭЭ БА ХИЙГДЭХ АЖЛУУД

Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй хатуу, шингэн, хий төлөвт бүх хорт болон аюултай бодис материалуудад хамаарна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдах химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ нь дараах чиглэлээр хийгдэнэ. Үүнд:

1. Эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ
2. Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ
3. Осол аюулын эрсдэлийн үнэлгээ

Эрүүл мэнд болон байгаль орчны эрсдэлийн үнэлгээг дараах агуулгын хүрээнд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Ашиглагдаж буй химийн хорт болон аюултай бодис нь агаарын чанарт (ажлын байрны агаар) нөлөөлснөөр ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох.
2. Ашиглагдаж буй химийн хорт болон аюултай бодис нь хөрсний чанарт нөлөөлснөөр байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох.
3. Ашиглагдаж буй химийн хорт болон аюултай бодис нь усны чанарт нөлөөлснөөр байгаль орчин үзүүлэх нөлөөллийг тодорхойлох.
4. Агаар, хөрс, усанд өөрчлөлт гарснаар ажилчдын эрүүл мэнд болон байгаль орчин гарах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлох.

Осол аюулын эрсдэлийн үнэлгээг дараах агуулгын хүрээнд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Химийн хорт болон аюултай бодис ашиглаж буй үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй аюул ослыг тодорхойлох.
 2. Эдгээр үүсэж болох осол бүрийн тохиолдох магадлал болон үзүүлэх нөлөөллийн хүчийг тодорхойлох.
 3. Дээр дурдсан аюул ослын тохиолдлын үед хичнээн хүн, мал болон ховордсон амьтан, ургамал өртөх магадлалтайг тодорхойлох.
 4. Тогтоосон ослын тохиолдлын үед эрсдлийг бууруулах талаар зөвлөмж боловсруулах.
- Эрүүл мэнд болон байгаль орчны эрсдэлийн үнэлгээгээр дараах асуудлуудыг тодорхойлно.

Үүнд:

1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөлд өртөж болох хүн болон экологийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох.
2. Хүн болон экологийн бүрэлдэхүүн хэсэг бохирдуулагчид өртөх замыг тогтоож, ямар сөрөг нөлөө үзүүлж болохыг тодорхойлох.
3. Бохирдуулагч бодист өртөх байдал болон түүний хоруу чанарт үндэслэн хүний эрүүл мэнд, байгаль орчинд учрах эрсдэлийн хүчийг үйлдвэрийн хэмжээнд гаргах.
4. Эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх болсон тохиолдолд тохиромжтой хувилбарыг санал болгох.

Осол, аюулын эрсдэлийн үнэлгээний хүрээнд дараах хүчин зүйлийг тогтооно:

1. Ажиллагсад болон тухайн орчинд амьдарч буй хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд аюултай нөлөө үзүүлж болзошгүй осол, аюул байгаа эсэхийг тодорхойлж, эрсдэлд өртөгчдөд үзүүлэх нөлөөлөл, түүний үр дагаврыг тогтоох.
2. Эрсдлийг бууруулах арилгах арга хэмжээг тодорхойлж, боломжит хувилбаруудыг санал болгох.

5. БҮТЭЭГДЭХҮҮН

Ажил гүйцэтгэгч нь дараах бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгнө. Ажлын даалгаварт тусгасан тайлан гаргаж өгнө. Үүнд: хураангуй тайлан (техникийн бус жирийн хүмүүст зориулсан), өртөлтийн үнэлгээ, хор аюулын үнэлгээ, эрсдлийг тодорхойлох, эрсдлийг бууруулах зөвлөмж, дүгнэлт зэрэг багтана.

6. ТАЙЛАГНАЛ БА УДИРДЛАГА

Ажил гүйцэтгэгч нь Эрдэнэт үйлдвэр ХХК-тай “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу гэрээ байгуулна. Ажил гүйцэтгэгч нь ажлын тайланг Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Хөгжлийн хэлтэст гаргаж өгөх үүрэг хүлээнэ. Ажил гүйцэтгэгч нь ажлын удирдамжид заасан ажлуудыг бие даан гүйцэтгэнэ. Гарах бүтээгдэхүүнүүдийг монгол хэл дээр боловсруулж цаасан болон электрон хэлбэрээр хүлээлгэн өгөх үүрэг хүлээнэ. Тус ажлын удирдамжид талуудын зөвшилцлийн үндсэн дээр ажлын хамрах хүрээ, зорилгод өөрчлөлт оруулж болно.

7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Ажил эхлэх хугацаа: Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр.

Ажил дуусах хугацаа: Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1,5 сар

8. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ БА ХУВААРЬ

Зөвлөх үйлчилгээний төлбөр нь Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохицуулагдах ба үр дүнд суурилсан төлбөрийн нөхцлөөр хийгдэнэ. Төлбөрийг шаардлага хангасан бүтээгдэхүүн боловсруулсан тохиолдолд зөвлөхийн ажлыг хүлээн авсан акт үйлдсэний дараа 100% хийнэ.

9. АЖЛЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Бүх шатны ажилд Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн холбогдох мэргэжилтэнүүд хяналт тавина.

10. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий байгууллага;

Техникийн баримт бичиг боловсруулах, туршилт судалгаа хийх, санал дүгнэлт гаргах, удирдан зохион байгуулах чадвартай багтай байх /багийн гишүүд тус чиглэлээр мэргэшсэн байх/; мөн хариуцлага хүлээх чадвартай байх;

Тухайн чиглэлээр ажил гүйцэтгэж байсан 3-5 жилийн туршлагатай байх;

Зөвлөх, түүний ажилтнууд нь компанийн нууц мэдээллийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг чандлан хадгалах.

11. ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК-Д АШИГЛАГДАХ ХИМИЙН БОДИСЫН ЖАГСААЛТ

№	Нэр	Томъёо	Хэмжээ, тн/жилд
1	Аммонийн нитрат	NH_4NO_3	10 000
2	Сүвэрхэг аммонийн нитрат	NH_4NO_3	2 000
3	Натрийн нитрат	NaNO_3	1 500
4	Карбамид /мочевина/	NH_2CONH_2	500
5	Эмульгатор	Iod 65-74	300
6	Натрийн нитрит	Na_2NO_2	30
7	Тиокарбамид	NH_2CSNH_2	20
8	Хүхэрт натри	Na_2S	13 000
9	Баяжуулалтын хөөсрүүлэгч урвалж BK-202 Frother 103 Menthyl isobutyl carbinal MIBV Polyfroth H19 Polyfroth H27 Polyfroth W22C Polyfroth H30 OnePrep F-603 Nasfroth FCM-70	$\text{C}_6\text{H}_{14}\text{O}$	800
10	Баяжуулалтын цуглуулагч урвалж BK-901 B AEROMX 5140 AEROMX 7260 AEROMX 5152 Xanthate Aerofloth AP Реагент IPETS /aero 3894/	$\text{C}_8\text{H}_{18}\text{O}$	700
11	Налко 71661		20
12	Давсны хүчил	HCl	8

13	Хүхрийн хүчил	H ₂ SO ₄	5
14	Шингэн шил	SiO ₂	480
15	Лигносульфанат	OCH ₃	200
16	Фураны давирхай	SQG-100	80
17	Урвалж хурдасгагч	C ₁₂ H ₂₅ -OSO ₃ H	15
18	Урвалж хурдасгагч	C ₁₂ H ₂₅ -OSO ₃ H	8
19	Магнийн хлорид	MgCl ₂	300
20	Антиаксилант MDC 220		20
21	Натрийн шүлт	NAOH	5
22	Тринатрифосфат	Na ₃ PO ₄	5
23	Сольвент		25
24	Силикагель	SiO ₂ *H ₂ O	3
25	Цеолит NaA	Na ₂ O, Al ₂ O ₃ *SiO ₂ *mH ₂ O	1
26	Шингэн хлор	Cl ₂	14
27	Карбид кальци	CaC ₂	120
28	Парафин	C ₁₇ H ₃₃	100
29	Давирхай /Смола/		10
30	Цэвэрлэгээний бодис		1
31	Салгагч бодис		1
32	Силикокальци	CaSi	30
33	Ханаагүй полиэфир, акрилийн давирхай		4
34	Метилэтилкетоны хэт ислийн уусмал		2
35	Нафтенат кобальт		0,1
36	Тунгалаг акрилан будаг хар, улаан, цагаан, шар		3
37	Будаг FQ-7		25
38	Будаг FOT-290		40
39	Хөөс дарагч		2
40	Техникийн сод	Na ₂ CO ₃	15000
41	Шингэн шил	Na ₂ SiO ₃	
42	Ацетон	C ₃ H ₈ O	2,5
43	Асбест /хризотил/	Mg ₃ Si ₂ O ₅ (OH) ₅	0,1
44	AERO 7360		45000
45	Aerofroth 70+		
46	Dowfroth 250A		
47	Амин TEA-700	ISOCURE TEA-700 Catalyst Triethylamin XY-700	0,5
48	Полиакриламид	CH-CH(CONH ₂) _n	60
49	Аминат К		25
50	Бензин		600
51	Бензин		300
52	Бензин		600
53	Дизель түлш өвлийн		15000
54	Мазут М-100		800
55	Газ		200
56	Керосин		5
57	Лак		10
58	Бэхжүүлэгч катализатор GSO3	C ₁₂ H ₂₅ -OSO ₃ H	25
59	Бэхжүүлэгч катализатор GSO9	C ₁₂ H ₂₅ -OSO ₃ H	25
60	Дизель түлш зуны		15000
61	Давирхай /Смола, Furan resing SQG-100/		35
62	Хөөс дарагч OrePrep Detoamer 202		2

Долоо. Жишиг маягт

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____ Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____